



ТӨВ АЙМАГ ЗУУНМОД СУМ

**БШУЯ-НЫ ХАРЬЯА ҮНДЭСНИЙ ЛАБОРАТОРИ
“ХҮМҮҮН” ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН**

**ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор

Т.Майцэцэг

Утас: 70273204 99018619

И-Мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сар 09

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургууль 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / ТӨВ-2017/150/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай болон нийцлийн аудит 4200-р стандарттай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 10-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургууль нь 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 2-наас 2017 оны 03 дүгээр сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 11-нд Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн шууд захирагч нь Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1-д “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон

нормативт зардлаар санхүүжүүлнэ. 40.2-д Төрийн өмчит бүх шатны сургууль, цэцэрлэгийн тогтмол зардал, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч “ гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” 16 дугаар зүйлийн 16.4.18-д төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна гэж заасны дагуу Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг БСШЯмнаас баталж Төв аймгийн Зуунмод сумын төрийн сангаар олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиуд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Мэргэжлийн хяналтын газрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 7 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. Сангийн яамны зөвшөөрөл бүхий ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн асcolous программ уялдсан байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг

хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж хянахад Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй. Дотоод хяналт шалгалтын тайлан ирүүлээгүй байна. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Хүмүүн цогцолбор сургуулийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 3313607.8 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулахаар төсөв батлагдсан, гүйцэтгэлээр улсын төсвөөс 3313607.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулаагүй үлдэгдэл 18586.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлснийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулгаар тайлагнасан.

Өөрийн орлогоор 177.3 мянган төгрөг төвлөрүүлэхээс 60.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба энэ өмнөх оны төсвийн хэмнэлтийн орлого байна.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 13049.1 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан. ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар 2016 оны 10-р сарын байдлаар хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар тус байгууллага нь нийт 25 мэдээлэл байршуулахаас 24 мэдээллийг байршуулж, 1 мэдээлэл байршуулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн үе шатанд 7 горим, нарийвчилсан сорилыг хийж гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдэл өмнөх оны элэгдлийн зардлаас өндөр байсан нь дахин тооцоололлоор 140992.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. НББ-ийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.2-д Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана. УСНББОУСтандарт-76, 77, 78, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

2. Санхүү үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн орлого 3115.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор, санхүү үр дүнгийн тайланд 3021.5 мянган төгрөгийг төсөв захирагчаас гэж тайлагнасан. Батлагдсан төлөвлөгөөгөөр 177.3 мянган төгрөгийн өөрийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 60.0 мянган төгрөг тайлагнасан. Энэ нь өмнөх оны хэмнэлтээс ирүүлсэн эх үүсвэр байна. Төсвийн тухай хуулийн 47-р зүйлийн 47.2-д “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасныг болон Санхүүгийн “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад 6136.5 мянган төгрөгийн алдааг залруулсан. Батлагдсан өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгсөн.

3. Төсвийн гүйцэтгэлийг аудитад ирүүлсэн тайлангаар 3318682.2 мянган төгрөгөөр буюу 23601.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 54-р зүйлийн 54.5-д Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

4. ХЦС-ийн бага ангиудын сурагчдын үдийн цайны 9-12-р сарын зардлыг олгосон ирцийн бүртгэлийг Жижүүр багшийн дэвтэртэй тулган шалгахад ирцийн бүртгэлийн тоо мэдээлэл засвартай, 12-р сарын 21-28-ний өдрийн хүүхдийн ирцийг 100 хүүхдээр илүү зарцуулан бүртгэсэн. Дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материалыг хоолны технологийн карттай тулган шалгахад хоолны нэр төрлийн дагуу боловсруулсан технологийн карт байхгүй тул материалын зарцуулалтыг тулгах боломжгүй байв. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Анхан шатны баримтын хөтлөлтийг сайжруулах, хоолны технологийн картыг боловсруулан батлуулж түүний дагуу хоолны захиалга ордерыг холбогдох албан тушаалтан хянаж байх талаар зөвлөмж өгөв.

5. Жилийн эцсийн 313.5 мянган төгрөгийн авлага, 93.4 мянган төгрөгийн өглөгийг төсвийн гүйцэтгэлийн мэдээнд мэдээлээгүйгээс төсвийн тайланд /бүлэгтэй/ өр, авлага байхгүй байна. НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Харилцагч байгууллагатай сар улиралаар тооцоо нийлж, авлага өглөгийг төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланд үнэн зөв мэдээлж, тайлагнаж байх талаар зөвлөмж өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 170730.2 мянган төгрөгийн материаллаг алдаа залруулагдсан. Материаллаг бус алдаа зөрчил нь зарцуулагдах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Тус байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн Цогцолбор Сургууль гэсэн нэртэй, үндсэн үйл ажиллагааны чиглэл нь ЕБС-ийн дунд сургуулийн үйл ажиллагаа гэж заасан. Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Одоогоор тус лаборатори сургуулийн харьяанд СӨБ-ийн үйл ажиллагаа эрхлэсэн 2 Цэцэрлэг үйл ажиллагаа явуулж тусдаа санхүүгийн тайлан бэлтгэж байна. Эдгээр 2 байгууллагын зорилго зорилт өөр, тусдаа хууль тогтоомжоор зохицуулагддаг байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад баримтыг хэсэгчлэн шалгасан ба гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй хөрөнгийн тооллогыг ажиглах, үндсэн хөрөнгөөс түүвэрлэн хяналтын тооллого хийх болон аудитаар илэрсэн зөрчилтэй асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 170907.5 мянган төгрөгийн, материаллаг бус 466.9 мянган төгрөгийн буюу нийт 171374.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.Үүнд:

1. Материаллаг хэмжээний нийт 170907.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 170730.2 мянган төгрөгийн алдааг залруулсан
2. Материаллаг бус 466.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Хүмүүн цогцолбор сургуулийн 2015 оны санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Урьдчилан тогтоосон материллаг байдлын түвшин 35822.1 мянган төгрөгнөөс материаллаг хэмжээний залруулагдаагүй алдаа нь хэтрээгүй тул зөрчилгүй санал дүгнэлт өгөв.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ

2017 оны 03 сарын 09